



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 512

Улаанбаатар хот

Биет бус хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.5.1, 5.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1058 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 881,260,150.00 (найман зуун наян нэгэн сая хоёр зуун жаран мянга нэг зуун тавин) төгрөгийн балансын үнэ бүхий 66510.2 м.кв биет бус хөрөнгийг /газар эзэмших эрх/ Шинжлэх ухааны академид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шинжлэх ухааны академийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б. Авид, Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч И.Түвшинтогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Биет бус хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИИН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

D.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ